

## ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2016-03-24 15:48:56

2016 оны 03 сарын 24-ний өдөр

Дугаар А/238  
Улаанбаатар хот

### Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/291 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шинээр ажилд орох болон албан тушаал дэвшүүлэн ажиллуулахад мөрдөх нийтлэг журам”-д оруулах өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх журмын өөрчлөлтийг байгууллагынхаа хөдөлмөрийн “Дотоод журам”-д тусган хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ Э.БАТ-

ҮҮЛ

**“НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГУУДАД ШИНЭЭР АЖИЛД ОРОХ БОЛОН  
АЛБАН ТУШААЛ ДЭВШҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХАД МӨРДӨХ  
НИЙТЛЭГ ЖУРАМ”-Д ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ**

“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шинээр ажилд орох болон албан тушаал дэвшүүлэн ажиллуулахад мөрдөх нийтлэг журам”-ын 4.3.1, 4.3.2, 4.3.3, 4.3.4, 4.4 дэх заалтуудыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

“4.3.1. Нийслэлийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаа, тухайн байгууллагын дүрэм, эрхэм зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, онцлог, түүхэн замнал, хөдөлмөрийн дотоод журам, хамт олны соёлыг танилцуулах нэгдсэн сургалтад хамруулах ба уг сургалтыг нийслэлийн Засаг даргын Тамгын газраас сар тутам нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв дээр зохион байгуулах;

4.3.2 Нэгдсэн сургалтад хамрагдсан ажилтныг туршилтын хугацаанд энэ журмын 4.3.3, 4.3.4, 4.3.5-д заасан ажлын байранд шаталсан байдлаар 3 сараас доошгүй хугацаагаар ажиллуулах;

4.3.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад анх ажилд орж буй ажилтныг дараах ажлын байранд шат дараалан ажиллуулна:

а/ Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд угтах үйлчилгээ, иргэдийн эрэлт, хүсэлт хариуцсан мэргэжилтний, эсхүл иргэдтэй өдөр тутам харилцах асуудал эрхэлсэн мэргэжилтний; /3 сараас доошгүй/

б/ Үндсэн албан тушаалын / 6 сар хүртэл/

4.3.4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт орж буй ажилтныг дараах ажлын байранд шат дараалан ажиллуулна:

а/ Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн иргэд хүлээн авах ажилтан, иргэдийн эрэлт, хүсэлт хариуцсан мэргэжилтний; /3 сараас доошгүй/

б/ Үндсэн албан тушаалын / 6 сар хүртэл/

4.4. Тухайн албан хаагчийн туршилтын хугацаанд ажилласан цалинг ажилд авч буй үндсэн байгууллага холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгоно.”